



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 14 өдөр

Дугаар 197

Улаанбаатар хот


Эрх шилжүүлэн ажил
гүйцэтгүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2015 оны Улсын төсвийн хөрөнгөөр эрүүл мэндийн салбарт 2015 онд хэрэгжүүлэх, ХҮ1.1.2.1 Харьяа газрын засвар /улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээний 7-д батлагдсан төсвөөс Бүгд Найрамдах Энэтхэг Улсын засгийн газрын тусламжаар Хавдар судлалын үндэсний төвд ирэх туяа эмчилгээний аппаратуудыг суурилуулж угсрах, хуучин тоног төхөөрөмжийг буулгаж зөөвөрлөх, засвар, үйлчилгээнд шаардагдах 64,526,500 /жаран дөрвөн сая таван зуун хорин зургаан мянга таван зуун/ төгрөгийн төсвийн зарцуулах эрхийг Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал /Л.Төмөрбаатар/-д шилжүүлсүгэй.

2. Дээрх ажлыг гүйцэтгэх худалдан авах ажиллагааг хууль, тогтоомжид заасны дагуу зохион байгуулж ажиллахыг Хавдар судлалын үндэсний төвийн ерөнхий захирал /Л.Төмөрбаатар/-д үүрэг болгосугай.

3. Эрх шилжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс /Т.Баярсайхан /-т даалгасугай.



САЙД

Г. ШИЙЛЭГДАМБА

D:\barimt\tushaal

080661